



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/513

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.5 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Иргэний нисэхийн ерөнхий газрын шагнал олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, анкетын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Иргэний нисэхийн ерөнхий газрын шагнал олгох журам”-ыг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, хууль, эрх зүйн хэлтэс (3.Туяа)-т даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн  
1/372 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэхэд, идэвхи санаачилга гарган, үр бүтээлтэй ажиллаж буй Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид "ИНЕГ" гэх/-ын ажилтнууд болон салбарын бусад байгууллагын ажилтнуудыг ИНЕГ-ын шагналаар шагнаж урамшуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Ажилтныг гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүн, байгууллагад оруулсан хувь нэмрийг үнэлэн шагнаж урамшуулна. Шагнал нь тухайн ажилтны ажлын идэвхи санаачилгыг өрнүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хөшүүрэг болохуйц байна.

### ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1. ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжид шагнал нь дараах хэлбэртэй байна.  
Үүнд:

2.1.1. Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэх;

2.1.2. Төрийн захиргааны удирдах дээд байгууллагуудын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх;

2.1.3. Бусад байгууллагын шагналаар шагнаж, урамшуулах;

2.2. ИНЕГ-ын шагнал нь дараах төрөлтэй байна.

2.2.1. Иргэний нисэхийн "Хүндэт ажилтан" тэмдэг;

2.2.2. "Хүндэт дэвтэр"-т бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

2.2.3. "Жуух бичиг";

2.2.4. "Баярын бичиг";

2.3. Шагналын тэмдэг, үнэмлэх, гэрчилгээний загварыг ИНЕГ-ын даргын зөвлөлөөр хэлэлцэж, тушаалаар баталгаажуулна.

### ГУРАВ. ШАГНАЛ ОЛГОХ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1. ИНЕГ-ын шагналаар шагнахад дор дурдсан ерөнхий үзүүлэлтийг харгалзана.  
Үүнд:

3.1.1. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, дэвшилтэт шинэ техник, технологи, шилдэг арга ажиллагаа эзэмшин нэвтрүүлэхэд идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан;

3.1.2. Иргэний нисэхийн салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, салбарын хөгжилд онцгой үр дүн өгөхүйц эрдэм шинжилгээ, судалгааны шинэ нээлт, бүтээл туурвисан;

3.1.3. Онцгой амжилт гаргасан, тогтвортой ажиллаж, мэргэжлийн ур чадвар, түвшин, ажлын гүйцэтгэл нь өндөр үзүүлэлттэй үнэлэгдсэн (энэ тохиолдолд онцгой амжилт гаргасныг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар);

3.1.4. Техник, тоног төхөөрөмж, үйлдвэрлэл үйлчилгээнд учирч болох ноцтой аваар ослоос урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирлын хор, уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн;

3.1.5. Байгууллагын соёл, үнэт зүйлийг эрхэмлэн, ажилтны болон мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхэд үлгэрлэгч байсан;

3.2. ИНЕГ-ын шагналыг олгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан олгоно.  
Үүнд:

3.2.1. Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, салбартаа 25-аас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, гаргасан амжилт бүтээл нь салбартаа үнэлэгдсэн, өндөр ур чадвартай ажилтныг Иргэний нисэхийн "Хүндэт ажилтан" тэмдгээр шагнана.

3.2.2. Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан, салбартаа 15-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажилд нээлт, ололт гаргасан тэргүүний ажилтныг ИНЕГ-ын "Хүндэт дэвтэр"-т нэрийг нь бичиж, дурсгалын гэрчилгээ олгоно.

3.2.3. Иргэний нисэхийн салбарт 5-аас дээш жил тогтвортой, үр бүтээлтэй ажилласан ажилтныг "Жуух бичиг"-ээр шагнана.

3.2.4. Иргэний нисэхийн салбарт 3-аас дээш жил тогтвортой ажилласан, ажлын өндөр амжилт гаргасан ажилтныг "Баярын бичиг"-ээр шагнана.

#### ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ

4.1. Ажилтныг үндсэн байгууллага, нэгжийн удирдлагын саналыг харгалзан шагналд нэр дэвшүүлэх буюу шагнал олгоно. Ажилтныг шагналд нэр дэвшүүлэхдээ үндсэн байгууллагын дарга тодорхойлолт гарган, саналаа бичгээр ИНЕГ-т ирүүлэх ба Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нэгтгэн удирдах дээд байгууллагад уламжлах зарчмыг баримтална.

4.2. ИНЕГ-ын шагналаар иргэний нисэхийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагаас нэр дэвшүүлж болно.

4.3. Шагналд нэр дэвшүүлж буй байгууллага нь шалгуур хангасан ажилтны холбогдох баримт бичгийг тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос нэг сараас доошгүй хугацааны өмнө ИНЕГ-т ирүүлэх ба заасан хугацаанаас хожимдож ирүүлсэн баримт

бичгийг хүлээн авч шийдвэрлэхгүй. Мөн шаардлага хангаагүй ажилтан (иргэн)-ыг шагналд нэр дэвшүүлэн ирүүлсэн материалыг буцаана.

4.4. Шагналд нэр дэвшигчийг тодорхойлохдоо дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

4.4.1. Шагналд нэр дэвшүүлэх тухай байгууллагын албан бичиг;

4.4.2. Ажил байдлын тодорхойлолт; (Шагнуулах үндэслэлийг тодорхой тусгах ба ажлын үзүүлэлт, амжилт, судалгааны хамт)

4.4.3. Хамт олны хурлын тэмдэглэл;

4.4.4. Батлагдсан загварын дагуу гаргасан анкет; (цээж зураг 3х4 см)

4.4.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;

4.4.6. Нийгмийн даатгалын лавлагаа ("Хүндэт ажилтан" тэмдэг, "Хүндэт дэвтэр"-т бичих шагналд хамаарна)

4.4.7. Шагналд нэр дэвшигчийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй.

4.4.8. Шагналын асуудлаар салбар, нэгжийн дарга нар ИНЕГ-ыг алгасан удирдах дээд байгууллагуудтай шууд харьцахыг хориглоно.

## ТАВ. ШАГНАЛ ОЛГОХ

5.1. ИНЕГ-ын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох байгууллагуудаас шагнуулахаар нэр дэвшүүлэн ирүүлсэн баримт бичгийн бүрдэлт, агуулгыг судлан, санал боловсруулж, шийдвэрийн төслийг Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн даргаар хянуулж, ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шагнал олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.

5.2. Энэхүү журмын 2.2-т дурдсан шагналыг ИНЕГ-ын даргын зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар олгоно. Үүнд:

5.2.1. "Хүндэт ажилтан" тэмдгийг Иргэний агаарын тээвэрчдийн өдрийн 5 болон 10 жилийн тэгш ойн баяраар (Онцгой амжилт гаргаж, тэр нь байгууллагад үр ашгаа өгсөн тохиолдолд хугацаа харгалзахгүй);

5.2.2. "Хүндэт дэвтэр"-т бичих шагналаар Иргэний агаарын тээвэрчдийн өдрийн 5 болон 10 жилийн давтамжтай тэгш ойн баяраар; (Онцгой амжилт гаргаж тэр нь байгууллагад үр ашгаа өгсөн тохиолдолд хугацаа харгалзахгүй);

5.2.3. "Жуух бичиг" болон "Баярын бичиг"-ээр Иргэний агаарын тээвэрчдийн өдөр, Шинэ жилийн баяр, салбарын тэмдэглэлт болон бусад баяраар.

5.3. ИНЕГ-ын шагналд дараах мөнгөн шагналыг дагалдуулан олгоно. Үүнд:

5.3.1. “Хүндэт ажилтан тэмдэг”-ээр шагнахад 500,000 төгрөг дагалдаж, орон нутгийн агаарын шугамд жилд нэг удаа, олон улсын агаарын шугамд дотоодын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг нисэж байгаа чиглэлд 2 жилд нэг удаа зорчих ба тээврийн зардлыг ажилтны харьяалах аж ахуйн нэгж, байгууллага хариуцна. Ингэхдээ орон нутаг болон олон улсад зорчих эрхийг нэг жилд давхардуулан олгохгүй ба гадаадад зорчих хөнгөлөлтийн хоорондох хугацаа 24 сар, орон нутагт зорчих хөнгөлөлтийн хугацаа 12 сараас багагүй байна.

5.3.2. “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж дурсгалын гэрчилгээ олгоход 500,000 төгрөг;

5.3.3. “Жуух бичиг”-ээр шагнахад 300,000 төгрөг;

5.3.4. “Баярын бичиг”-ээр шагнахад ИНЕГ, түүний салбар, нэгжийн ажилтанд 200,000 төгрөг, салбарын яам, агаарын тээвэрлэгч компаниудын болон бусад аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтанд 100,000 төгрөг;

5.4. Иргэний нисэхийн салбараас төрсөн гавьяат болон түүнээс дээш цолтой ИНЕГ-ын өндөр настанд Иргэний агаарын тээвэрчдийн өдрөөр хүндэтгэл үзүүлэн “ИНЕГ-ын даргын нэрэмжит шагнал”-аар шагнах бөгөөд энэхүү шагналыг 500,000 төгрөг дагалдана.

5.5. “Хүндэт ажилтан” тэмдэг шагналыг ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжийн бус иргэнд олгож болно. Энэ тохиолдолд зөвхөн тэмдэг, үнэмлэхийг олгох бөгөөд энэ журмын 5.3.1 дэх заалт үйлчлэхгүй.

5.6. Монгол Улсын төрийн дээд шагнал болон “Салбарын тэргүүний ажилтан” цол тэмдэг, Иргэний нисэхийн “Хүндэт ажилтан” тэмдгээр нэг хүнийг нэг удаа шагнуулах ба давхардуулахгүй.

5.7. Монгол Улсын төрийн дээд шагналаар шагнагдсан ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжийн ажилтан, харьяаллын өндөр настан болон Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Гавьяат цолоор шагнагдсан иргэний нисэхийн салбарын байгууллагын ажилтныг ИНЕГ-ын даргын зөвлөл хүлээн авч 300,000 (гурван зуун мянга) төгрөгтэй дүйцэхүйц бэлэг дурсгалын зүйл гардуулна.

5.8. Жилийн эцсийн ажлын үр дүнг зохион байгуулалтын нэгж тус бүрээр дүгнэж шилдэг нэгж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж байгууллагад учирч болзошгүй онц их хэмжээний хохирлоос урьдчилан сэргийлсэн, арилгасан, хэмнэлт гаргасан, орлого нэмэгдүүлсэн ажилтныг шилдэг ажилтан, шилдэг менежер, шинэ бүтээл санаачилсан бол шилдэг бүтээл гэсэн төрлөөр шагнана.

5.8.1. Шилдэг салбар, нэгж - 10 сая төгрөг;

5.8.2. Шилдэг ажилтан - 5 сая төгрөг;

5.8.3. Шилдэг менежер - 5 сая төгрөг;

5.8.4. Шилдэг бүтээл (Шилдэг бүтээлийн шагналын хэмжээг тус газрын даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.).

5.9. Байгууллага, хамт олны дунд зарласан болзолт болон ажил мэргэжлийн уралдаан, тэмцээний үр дүнгээр салбарын тэргүүний байгууллага, нэгж, ажилтныг шалгаруулж, мөнгөн шагналаар шагнана.

## ЗУРГАА. ШАГНАЛЫН САН БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ

6.1. Иргэний нисэхийн ерөнхий газрын шагналын санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

6.1.1. Шагнал урамшууллын болон баяр ёслолын зардал;

6.1.2. Батлагдсан төсвийн хэмнэлт;

6.1.3. Бусад эх үүсвэр;

6.2. "Хүндэт ажилтан" тэмдэг болон "Баярын бичиг"-ээр шагнагдсан ажилтанд шагналын дагалдах мөнгөн шагналыг ИНЕГ-ын шагналын зардлаас олгох ба "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн болон "Жуух бичиг"-ээр шагнагдсан ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, өндөр настанд олгох шагналын дагалдах мөнгөн шагналыг нэр дэвшүүлэгч байгууллага нь хариуцна.

6.3. ИНЕГ-ын шагналаар шагнуулсан гадаадын иргэнд мөнгөн шагнал болон дагалдах эрхүүдийг олгохгүй.

## ДОЛОО. ШАГНАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САН

7.1. ИНЕГ болон харьяа салбар нэгж нь шагналын талаар дараах мэдээллийн нэгдсэн сантай байна. Үүнд:

7.1.1. Энэхүү журмын дагуу "Хүндэт ажилтан тэмдэг"-ээр шагнагдсан иргэдийн мэдээлэл (зорчих эрх эдэлсэн иргэдийн судалгаа);

7.1.2. "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн иргэдийн мэдээлэл;

7.1.3. "Жуух бичиг", "баярын бичиг"-ээр шагнагдсан иргэдийн мэдээлэл;

7.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмыг батлах тухай" 1999 оны 71 дүгээр зарлигийн дагуу Монгол Улсын цол хүртсэн, одон, медалиар шагнагдсан Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа алба салбаруудын ажилтнуудын мэдээлэл;

7.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт, хөдөлгөөнийг Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2024 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн  
... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШАГНАЛААР  
ШАГНАГДАХ ИРГЭНИЙ АНКЕТ  
(Загвар)

3x4

1. Овог, нэр:
2. Регистрийн дугаар:
3. Хүйс:
4. Боловсрол, мэргэжил:
5. Одоо ажиллаж байгаа салбар нэгж, байгууллага:
6. Ажилласан жил (улсад болон Иргэний нисэхийн салбарт):

| № | Ажлын газрын нэр | Хугацаа | Эрхэлсэн ажил |
|---|------------------|---------|---------------|
| 1 |                  |         |               |
| 2 |                  |         |               |
| 3 |                  |         |               |

7. Төр засгийн болон бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан:

| № | Шагналын нэр | Шагнагдсан он |
|---|--------------|---------------|
| 1 |              |               |
| 2 |              |               |

8. Шагнуулах үндэслэл: .....
- .....
- .....
- .....
- .....

9. Ямар шагналаар шагнуулах: .....

10. Хамт олны саналын хувь: .....

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА/ЗАХИРЛЫН ГАРЫН ҮСЭГ: